



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ыг 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/10/НА/СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Ч.Удвалноров

Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	6
3.1 Байгууллагын үйл ажилагаа	6
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	6
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	6
4. Аудитын тайлан	7
4.1 Ерөнхий зүйл	7
4.2 Дотоод хяналт	7
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
4.4 Материаллаг байдал	7
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	8
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
8. Аудитын илрүүлэлт.....	9
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нотлох аудит
ОНА	Орон нутгийн өмчит аж ахуй нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.03.15 № 264

танай _____-ны № _____-т

ХӨЛӨНБУЙР ХӨГЖИЛ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Ө.БАТБАЯР ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт
Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага
Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага
Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ



011020182

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,768,372.84	3,018,948.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,768,372.84	3,018,948.34
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,768,372.84	3,018,948.34
31210	Төгрөг	6,768,372.84	3,018,948.34
31213	Арилжааны банк дахь харилцах	6,768,372.84	3,018,948.34
33	АВЛАГА	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,768,372.84	3,018,948.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,768,372.84	3,018,948.34
51	Засгийн газрын хувь оролцоо	6,768,372.84	3,018,948.34
51200	Хуримтлагдсан үр дүн	6,768,372.84	3,018,948.34
51210	Өмнөх үеийн үр дүн	3,112,264.82	6,768,372.84
51220	Тайлант үеийн үр дүн	3,656,108.02	-3,749,424.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,768,372.84	3,018,948.34

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	50,084,245.42	45,385,259.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,084,245.42	45,385,259.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,084,245.42	45,385,259.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	50,084,245.42	45,385,259.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	46,428,137.40	49,134,683.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,428,137.40	49,134,683.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,428,137.40	49,134,683.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,428,137.40	49,134,683.50
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	46,428,137.40	49,134,683.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,656,108.02	-3,749,424.50
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,656,108.02	-3,749,424.50
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	6,768,372.84	6,768,372.84
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	6,768,372.84	6,768,372.84
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-3,749,424.50	-3,749,424.50
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	3,018,948.34	3,018,948.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	50,084,245.42	45,385,259.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,084,245.42	45,385,259.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,084,245.42	45,385,259.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	50,084,245.42	45,385,259.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,507,637.40	49,134,683.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,507,637.40	49,134,683.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,507,637.40	49,134,683.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,679,896.00	20,520,000.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	24,679,896.00	20,520,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,492,873.35	2,565,000.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	4,492,873.35	2,565,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,926,197.61	10,631,161.88
210301	Гэрэл, цахилгаан	4,030,517.61	6,948,247.88
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	895,680.00	3,682,914.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,408,670.44	0.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	12,408,670.44	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	15,418,521.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	15,418,521.62
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,576,608.02	-3,749,424.50
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,576,608.02	-3,749,424.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,191,764.82	6,768,372.84
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,768,372.84	3,018,948.34

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	төгрөг	50,084,244.98		45,385,259.00		
2	Нийт зардал	төгрөг	46,428,137.40		49,134,683.50		

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ын зорилго нь нийтийн эзэмшлийн хөрөнгийг арчлах, иргэдийн амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг иргэдэд үйлчлэх гэж тодорхойлжээ. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай байна. Өмч 100 хувь төрийн эзэмшилд байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ыг сумын ИТХ-ын 2014 оны 52 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;” гэж заасныг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
	1	2	3=2-1
Б			
Мөнгөн хөрөнгө	6,768,372.84	3,018,948.34	(3,749,424.5)
БХХО			-
Авлага			-
Урьдчилгаа			-
Бараа материал			-
Үндсэн хөрөнгө			-
Биет бус хөрөнгө			-

Нийт хөрөнгийн дүн	6,768,372.82	3,018,948.34	(3,749,424.5)
Өр төлбөрийн дүн			-
Богино хугацаат өглөг			
Урт хугацаат өглөг			-
Эздийн өмч			-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,768,372.82	3,018,948.34	(3,749,424.5)

Кассад бэлэн мөнгөний үлдэгдэлгүй байна.

Банкин дахь харилцах дансанд 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэлгүй байна.

Бараа материалын үлдэгдэлгүй байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ нь 2021 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Сумын ИТХ-аас 2021 оны төсвийг сумын хог хаягдал, засвар үйлчилгээнд зориулж ОНХС-гаас цэвэр орчин төслөөр 9.0 сая төгрөг, хоггүй Хөлөнбуйрчууд төслөөс 9.6 сая төгрөгийг нийт 18.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад хууль тогтоомжтой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Ч.Удвалноров нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж,

гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллага нь аймгийн төрийн сангаас гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байгаа ч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн тохирохгүй байгаа тул цаашид тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болох шаардлагатай байна.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас 2021 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тус байгууллага нь хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын дарга хэрэгжүүлэн ажилладаг байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны зардлын 46.4 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 0.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ нь тайлант онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулж байх зөвлөмж өгөв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх асуудал байхгүй.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

